



ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2024 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ





ОДООГИЙН БҮТЭЦ ЗОХИОН
БАЙГУУЛАЛТ

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 454 дүгээр тогтоолоор газрын харилцаа, геодези, зураг зүйн газрыг Монгол Улсын ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжсэн болно.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд орсон 2023 оны нэмэлт өөрчлөлт




ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ОРЛОГО /мян.төг/											
											2020 оноос хойш
№	Үзүүлэлт	2020-2022 оны төлбөрийн үлдэгдэл	2023 гүйцэтгэл				2024 он гүйцэтгэл				Нийт дутуу газрын төлбөр /2020-2024/
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дутуу	Хувь	Төлөвлөгөө	10 сарын 31-ний байдлаар гүйцэтгэл	Хүлээгдэж байгаа	Хувь	
1	Сүмбэр	295,003.3	311,220.0	147,261.0	163,959.0	47.3	370,065.8	224,689.00	145,376.84	60.72	604,339.17
2	Шивээговь	176,782.6	171,680.0	23,265.5	148,414.5	13.6	175,397.0	30,542.00	144,855.000	17.41	470,052.10
3	Баянтал	17,446.47	17,098.20	5,109.50	11,988.7	29.9	18,480.00	4,573.00	13,907.00	24.75	43,342.17
НИЙТ ДҮН		489,232.4	499,998.2	175,636.0	324,362.2		563,942.8	259,804.0	304,138.8		

Монгол улсын Газрын төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2. дахь заалт /Газрын төлбөрийн асуудал эрхэлсэн байгууллага /албан тушаалтан/ энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан газрын жилийн төлбөрийг ногдуулж тухайн оны 02 дугаар сарын 10-ны дотор татварын албанд хүргүүлнэ./

мөн 10 дугаар зүйлийн 10.4. дахь заалт /Татварын алба Татварын ерөнхий хуулийн дагуу газрын төлбөрийн ногдуулалт, төлөлтөд хяналт тавина./ гэж хуулинд нэмэлт өөрчлөлт өөрчлөлт орсон байна. Төсвийн тухай хуулийн 23.8.14 дахь заалтын дагуу газрын төлбөрийн орлого 100 хувь суманд төвлөрч, зарцуулагдаж байна.

Сумын нэр	Хээрийн тодруулга /сая төг/	Суурин хувийн хэрэг үүсгэх / сая төгрөг /
СҮМБЭР	4.5	29
ШИВЭЭГОВЬ	2.5	12.5
БАЯНТАЛ	2.5	12.5



Аймгийн хэмжээнд батлагдсан газар зүйн нэр: 552 нэр
(УИХ-ын 2003 оны 42 дугаар тогтоол)



42 ДУГААР ТОГТООЛЫН
ДАГУУ

ШИВЭЭГОВЬ СУМ, БАЯНТАЛ
СУМ АЖИЛ ДУУССАН. СҮМБЭР
СУМ ГАЗАР ЗҮЙН НЭРИЙН
ТОДОРУУЛАЛТЫН АЖИЛ
ХИЙГДЭЖ БАЙНА.



ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ

БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

1. ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ, /2024-2039/ ОН /69.8 САЯ/

- ✓ Монгол улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн 384 дугаар тогтоолоор “Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө” шинэчлэн батлагдсан. /АГЗБЕТ-шинэчлэх шаардлагатай болсон./

2. СУМДЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ /2024-2030/ ОН / 85.8 САЯ/

/Хэрэгжүүлэх хугацаа дууссан/



3. СУМДЫН ГАЗАР ЗҮЙН НЭРИЙН ХЭЭРИЙН ТОДРУУЛГА, ХУВИЙН ХЭРЭГ ҮҮСГЭХ АЖИЛ /2023-2024/ ОН

Сумын нэр	Хээрийн тодруулга /сая төг/	Суурин хувийн хэрэг үүсгэх /сая төгрөг/
СҮМБЭР	4.5	29
ШИВЭЭГОВЬ	2.5	12.5
БАЯНТАЛ	2.5	12.5

/2024 он 209,6 САЯ/





ШИЙДВЭРЛЭХ АСУУДАЛ

1. ГАЗРЫН ТӨЛӨВЛӨГӨӨТ ХЯНАН БАТАЛГАА

Аймгийн бэлчээрийн газрын болон хот тосгон, бусад суурины газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг 2020 онд Жэмп ХХК нь хийж гүйцэтгэн хүлээлгэж өгсөн бөгөөд дээрх хянан баталгааны ажлыг 5 жил тутамд Газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.2-т заасны дагуу төлөвлөгөөт хянан хийлгэх шаардлагатай байдаг болно. Уг газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны хугацаа 2025 оны 01 сард дуусгавар болж байна.

Төсөв-114'486'504.төгрөг

2. СУМБЭР СУМЫН 1:1000-НЫ МАСШТАБТАЙ БАЙР ЗҮЙ ЗУРАГ, ГАЗАР ДООРХ ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ЗУРГИЙГ СОЛБИЛЦОЛЫН ITRF 2020 ЭРИНД ШИЛЖҮҮЛЭХ

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоол, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 6.1 дэх зорилтын 6.1.5-д тусгагдсан арга хэмжээний хүрээнд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас боловсруулсан төвийн суурьшлийн хэсгийн 1:1000-ны масштабтай байр зүйн зураг, газар доорх шугам сүлжээний зургийг солбилцлын ITRF2020 эринд шилжүүлэх ажил

Төсөв-290.504.253

2. ШИВЭЭГОВЬ СУМЫН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ТАЛБАЙД АНХААРАЛ ХАНДУУЛАХ

Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах боломжгүй байна.

3. ӨМЧЛӨЛИЙН ЗОРИУЛАЛТААР ОЛГОСОН ГАЗАРТ ДЭД БҮТЦИЙН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ

-Сүмбэр сум- 6444 иргэнд газар өмчлүүлснээс 2237 иргэнд газар тогтой 4207 иргэний газар тоггүй
-Шивээговь сум-2087 иргэнд газар өмчлүүлснээс 687 иргэнд газар тогтой 1400 иргэний газар тоггүй
Баянтал сум-1706 иргэнд газар өмчлүүлснээс 300 иргэнд газар тогтой 1406 иргэний газар тоггүй



Газрын хянан
баталгааны дүгнэлт





АЛБАН БАЙГУУЛЛАГУУДАД ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ТАЛААР МЭДЭЭЛЭЛ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Байгууллагын даргын 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн баталсан “Албан байгууллагуудад газрын харилцааны талаар мэдээлэл хийх хуваарь”-ийн дагуу 32 албан байгууллагад мэдээлэл хийхээс нийт 12 байгууллагийн 175 иргэнд Газрын харилцааны хууль тогтоомжийг таниулан ажилласан..





ХӨДӨӨГИЙН БАГУУДЫН ӨДӨРЛӨГТ ОРОЛЦСОН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

2024 оны 05 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд Мөнх, Уулзвар, Малх багуудын өдөрлөгт Газрын удирдлагын хэлтсийн албан хаагчид болон Газар, геодези зураг зүйн улсын байцаагч оролцсон Газрын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт болон “Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд газрын харилцааны зүгээс хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар танилцуулга хийн нийт 184 гарын авлага тараан ажилласан.






2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Сүмбэр сумын Найрамдал багийн өдөрлөгт газрын харилцааны чиглэлээр нийт 70 ширхэг гарын авлагыг тараан ажилласан байна.





Монгол улсад Статистикийн алба үүсэж, бэхэжсэний 100 жилийн ойн хүрээнд иргэдэд зориулсан “Нээлттэй хаалганы өдөрлөг” 2024 оны 9 дүгээр сарын 20 ны өдөр зохион байгуулагдаж байгууллагын 8 албан хаагчид оролцон иргэдэд өөрийн байгууллагын үйл ажиллагааг танилцуулан, нийт 67 ширхэг ном болон тараах материалаар үйлчилгээ үзүүллээ.





СУМДЫН БАГИЙН ЗАСАГ ДАРГА НАР БОЛОН НИЙГМИЙН АЖИЛТНУУДАД ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ШИНЭЧЛЭЛТ, ӨӨРЧЛӨЛТҮҮДИЙН ТАЛААР СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛСАН

Сумдын багийн Засаг дарга нар болон нийгмийн ажилтнуудад Газрын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, төлөвлөлтүүдийн бичиг баримтуудын уялдаа холбоог хангах, Хаягжуулалтын тухай хуулийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах зорилгоор 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр сургалт зохион байгуулан ажиллалаа.

Сургалтад нийт 10 багийн Засаг дарга болон 3 багийн нийгмийн ажилтнууд хамрагдаж харилцан мэдээлэл солилцож цаашдын ажлын уялдаа холбоог сайжруулахад хэрхэн хамтарч ажиллах талаар зөвшилцөж ажиллалаа.





29.7.Монгол Улсын иргэн энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан газрыг эзэмших хүсэлтийг засаг захиргааны нэгж болон зориулалтаа сонгож нэг удаа гаргах бөгөөд тухайн иргэний хүсэлт шийдвэрлэгдэх хүртэл өргөдлийн бүртгэлийн мэдээллийн санд хадгалагдана.

2024 онд

386

29.8.Иргэний үнэ төлбөргүйгээр газар эзэмшихээр цахим системээр гаргасан хүсэлтийг дараах дарааллын дагуу эрэмбэлэн бүртгэнэ:


29.8.1.өмнө нь гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан хувийн гэр, орон сууцны хашаа барих болон хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамал тарих зориулалтаар үнэ төлбөргүй газар эзэмшиж байгаагүй иргэний хүсэлтийг жагсаалтын эхэнд, цахим системд хүсэлт гаргасан огноогоор;

29.8.2.энэ хуулийн 29.8.1-д зааснаас бусад иргэний хүсэлтийг цахим системд хүсэлт гаргасан огноогоор.

29.9.Иргэний үнэ төлбөргүй газар эзэмших хүсэлтийг өргөдлийн бүртгэлийн мэдээллийн санд бүртгэгдсэн дарааллын дагуу шийдвэрлэнэ.



ГАЗАР, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН БОЛОН БАРИЛГЫН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛИЙН ХҮРЭЭНД:




Шилэн хяналтын цахим системийг улсын хэмжээнд 2024 оны 05 дугаар сараас эхлэн ажиллуулж эхэлсэн. Шилэн хяналтын цахим хуудсаар:

- 10 объектийг төлөвлөгөөт шалгалт хийхээр,
- 128 объектод эрсдлийн үнэлгээ хийж тус тус үнэлээд байна.

Аймгийн Зөрчлийн тухай хууль, Газрын тухай хууль, Барилгын тухай хуулийг иргэд, олон нийт рүү чиглэсэн дараах арга хэмжээнд оролцон сурталчлан таниулах арга хэмжээ авч ажиллав. Үүнд:

- Байгууллагын болон олон нийтийн цахим орчинд Зөрчлийн тухай хуулиар 13 постер хийж оруулсан,
- Хөдөөгийн 3 багийн өдөрлөгт оролцохын зэрэгцээ 56 иргэн, хуулийн этгээдэд хууль, эрх зүйн зөвлөгөө өгч ажилласан.



Эрх бүхий байгууллагын
зөвшөөрөлгүйгээр газар ашигласан

бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг
гаргуулж хүнийг **таван зуун** нэгжтэй тэнцэх
хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг
таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний
төгрөгөөр торгоно



ГАЗАР, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН БОЛОН БАРИЛГЫН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛИЙН ХҮРЭЭНД

5

Төлөвлөгөөт шалгалт:

- 10 объект /ААН/

Илрүүлсэн зөрчил:

- 70

Арилгуулсан зөрчил:

- 58

2

3

Төлөвлөгөөт бус шалгалт:

- 5 ААН
- 17 иргэн

Илрүүлсэн зөрчил:

- 37

Арилгуулсан:

- 27

Албан шаардлага-2

Дүгнэлт-2

Торгууль-20.5 сая төгрөг

6

18

Урьдчилан сэргийлэх шалгалт:

- 13 ААНБ

Илрүүлсэн зөрчил:

- 23

Арилгуулсан зөрчил:

- 20

3

2

Гүйцэтгэлийн шалгалт:

- 12 ААН
- 17 иргэн /цахим/

Илрүүлсэн зөрчил:

- 92

Арилгуулсан зөрчил:

- 79

3




БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТЭС

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд нийтийн орон сууцны төсөл сонгон шалгаруулалтын нээлтийн үйл ажиллагааг аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг 2024.03.07-ны өдөр зохион байгуулж, сонгон шалгаруулалтаар “Өргөө засал” ХХК 144 айлын орон сууцны барилгын ажлыг гүйцэтгэхээр шалгарсан байна. Мөн Сүмбэр сумын 8 байршилд 1000 айлын орон сууц, 2 байршилд 80 айлын хаус хорооллын төсөл сонгон шалгаруулалтыг 2024.05.21-ны өдөр хүртэл дахин зарлаад байна. Байгууллагын зүгээс ажлын хэсэгт хамтран ажиллаж байна.

Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх ажлын гүйцэтгэгчээр “Сонголт дизайн” ХХК шалгарч, хагас жилийн байдлаар төлөвлөгөөг 100 хувь гүйцэтгэн, хүлээлгэн өгсөн





БАРИЛГЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Лаборатори 18 төрлийн багаж хэрэгсэлээр дараах сорил шинжилгээг 11 үзүүлэлтээр шинжилгээ хийх багаж тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. Үүнд

- Бетон сорьц
- Керамик тоосго
- Явган замын хавтан
- Эко хавтан
- Элс
- Хайрга, дайрга
- Хөөсөнцөр



ЧАДВАХЖУУЛАХ ДАДЛАГЫН ХҮРЭЭНД

2024 оны 08 сарын 26-30-ны өдрийг дуустал Барилгын хөгжлийн төвийн Барилгын материалын сорилт шинжилгээний итгэмжлэгдсэн лабораторид хийсэн дадлагын хугацаанд бетон сорьц, элс, хайрга, дайрга, сийрмэг бетон гулдмай, керамик тоосго, хөөсөнцөр, хуванцар хоолой, бетоны найрлага, явган зам талбайн хавтан, замын хашлагын шинжилгээг хийх, үр дүнг боловсруулах, цонхны дулаан техникийн тооцоог хийж сурсан.





БАРИЛГЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Жилийн эцсийн байдлаар Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа 13 объектын 6 төрлөөр материалаас 54 дээж аван лабораторийн шинжилгээг БХТ-тэй хамтран хийсэн байна.



- Онцгой байдлын газартай хамтран орон нутагт барилгын материал үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдэд үзлэг шалгалтын ажлыг зохион байгуулан ажилласан. Үүнд:
- Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй
- Галын аюулгүй байдал
- Хуулийн хэрэгжилт
- Тоног төхөөрөмжийн ашиглалтын заавар, аюулгүй ажиллагаа
- Үйлдвэр цехийн холбогдох барим бичиг зэрэгт




Улсын болон орон нутаг, төсөл хөтөлбөрөөр хэрэгжиж буй нийт 77 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлаас 2024 онд санхүүжигдэх 31,8 тэр бум төгрөгийн төсөвт өртөгтэй 45 ажилд захиалагчийн хяналтын гэрээг байгуулан ажиллаж байна. Үүнд:

- БХТөвтэй 14,4 тэр бум төгрөгийн 6 ажил
- АЗДТГ-тай 10,9 тэр бум төгрөгийн төсөвт өртөгтэй 15 ажил
- Сүмбэр сумын ЗДТГ-тай 2,2 тэр бум төгрөгийн төсөвт өртөгтэй 11 ажил
- Шивээговь сумын ЗДТГ-тай 1,5 тэр бум төгрөгийн төсөвт өртөгтэй 8 ажил
- Баянтал сумын ЗДТГ-тай 794,4 тэр бум төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ажил

АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ БАТАЛГААЖУУЛАЛТ


2024 оны 11-р сарын байдлаар Улсын төсвийн 7 объектын 8,6 тэрбум төгрөг, Орон нутгийн төсвийн 34 объектын 6,0 тэрбум төгрөгийн санхүүжилтийн гүйцэтгэлийг тус тус хянаж баталгаажуулсан байна.

ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР



□ Улсын төсвийн □ Орон нутгийн төсвийн □ Төсөл хөтөлбөр

Гүйцэтгэл





СУРГАЛТ ЗӨВЛӨГӨӨН

Сумдын Засаг Даргын Тамгын газрын дарга нар, хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэнүүдийг хамруулан төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг, худалдан авах ажиллагааны зарчим, барилга байгууламжийн захиалагч болон хяналт хэрэгжүүлэхэд анхаарах асуудал зэрэг сэдвээр сургалтыг зохион байгуулж, цаашид анхаарч ажиллах болон тулгамдаж буй асуудлын талаар санал солилцсон үр дүнтэй сургалт болсон.

“Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм”, “Барилгын хувийн хэрэг хөтлөх журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төрийн байгууллагуудын хувийн хэрэг хөтлөлтөд үзлэг шалгалт хийлээ. Үзлэг шалгалтыг 14 байгууллагад зохион байгуулж, гарын авлага материалыг тарааж, тухайн барилгад авах шаардлагатай байгаа арга хэмжээнд санал солилцон, зөвөлгөө зөвлөмж өгч ажилласан.





АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА